

Алсын хараа – 2050
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
“Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь / Дээд шатны байгууллагын үнэлгээ, тайлбар
Ес. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ							
71	9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.	9.3.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.	2020 - 2050	-	100 айл орчмын барилгын материалын үйлдвэрүүдийг шилжүүлэх ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ажиллах.	<ul style="list-style-type: none"> Паркийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ханын материалын үйлдвэрлэлийн бүс болон жижиг дунд үйлдвэрлэлийн бүсийг хамруулан 13 га газарт дэд бүтцийн шугам сүлжээ, зам талбайд тохируулан 0,05га /500м2/ эдэлбэр газар бүхий 126 аж ахуйн нэгжийн төлөвлөгөө боловсруулсан ба 2024 оны байдлаар 2 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулаад байна. 100 айлын барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа хийгдсэн ба эхний ээлжийн 26 аж ахуйн нэгж болох мод, чулуу, дээврийн төмөр, вакум цонхны үйлдвэрлэл эрхлэгчдийн нэрсийг гаргасан. Мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг барилгын материалын зах, бөөний төвүүдийн судалгааг хийсэн. 	100
132	9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.	9.5.1. Дагуул, хаяа хот, тосгоныг тус бүрд нь худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна.	2020 - 2050	-	НБМҮТП-ийн бүтцийн эхлүүлнэ.	<ul style="list-style-type: none"> Цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Уг барилга байгууламжийн “Налайх 110/35/10 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дууссан, дэд станцаас Паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил график, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил бүрэн дуусаж техникийн комисс ажиллаж 	100
134		9.5.5. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого	2021 - 2030				

		төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллана.					
138		9.5.9. Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татахын тулд үйлдвэр технологийн паркуудын газрыг худалдах, түрээслэх замаар эзэмшүүлнэ.	2021 - 2030				
139		9.5.10. Улаанбаатар хотын бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна.	2021 - 2030				
145		9.5.16. Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.	2021 - 2030				<p>байна. Дэд станцаас паркийн 110/10кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил бүрэн дуусаж агаарын шугамын хүчдэлээ өгч туршилт тохируулгын ажил хийгдэж байна. Нийт барилга угсралтын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй байгаа болно.</p> <ul style="list-style-type: none"> • Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй “Тэгш плант” ХХК нь үйлдвэрийн зориултай 2га газрыг мөн “Ногоон цагираг” ХХК 2,76 га газрыг хашаалж үйлдвэрээ паркт нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. • Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоогийн байдлаар 250 га газар дээр нийт 65 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа болон үйлдвэрийн барилга угсралтын ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд зарим үйлдвэрийн бүтээн байгуулалт ажил дуусаж тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. Дээрх үйлдвэрүүд ашиглалтад ороход 325 хүнийг байнгын ажлын байраар хангах ба одоогоор 3 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхэлж 162 хүнийг ажлын байраар хангаад байна. • Паркт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн ажиллах хүчний хэрэгцээний судалгааг гаргаж, сул орон тоо гарсан даруй Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст мэдээлэл хүргүүлэн, Налайх дүүргийн ажилгүй иргэдийг ажлын байраар ханган ажиллаж байна. одоогоор Налайх дүүргийн 112 иргэнийг тогтмол ажлын байраар хангаад байна. • Барилга, хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж 228.8 сая төгрөгөөр “Өрх” ХХК 2021.01.28-ны өдөр 2021/47 дугаар гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт хийгдэж байна.